

# МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

С.Мөнхбат

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш, доктор, дэд профессор

Б.Эрдэнэдалай

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн докторант

Дэлхийн улс орнуудад улс төрийн санхүүжилтийг хуулиар нарийн зохицуулах асуудал чухлаар тавигдаж ирсэн байдаг. Улс төрийн санхүүжилтийн асуудлыг хуулиар нарийн зохицуулснаар ардчиллыг бэхжүүлэх, намуудын дотоод ардчиллыг бий болгох, зохион байгуулалтын оновчтой бүтцийг бүрдүүлэх, үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй ил тод явуулах, сонгогчдын төлөө ажиллах зэрэг намыг өөрийг нь төлөвшүүлэхэд эерэг нөлөөллийг үзүүлдэг. Хамгийн гол нь тухайн орны улс төр, ардчиллын хөгжилд дэмжлэг болдог байна.

Монгол улс 1990 онд “Улс төрийн намуудын тухай” хуулийг анх батлан гаргасан. 2005 онд тус хуулийг шинэчлэн найруулж “Улс төрийн намын тухай” хууль нэртэйгээр УИХ-аас батлан гаргаснаар улс төрийн намын үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинд нэлээдгүй өөрчлөлтүүд гарсан. Ялангуяа намын санхүүжилтийн ил тод байдал, тайлاغналын зарчмыг олон улсын жишиг рүү ойртуулах алхмууд тус хуулиар хийгдсэн гэж үздэг. Гэвч цаашид боловсронгуй болгох асуудлууд нийгэм, улс төрийн хөгжлийн шаардлагаар гарч ирсээр байна. Өнөөдөр Монголын нийгэмд тулгараад байгаа улс төр, мөнгөний харилцааг маш нарийн зохицуулсан хууль, эрх зүйн зохицуулалтыг хийх шаардлагатай байгаа юм.

Учир нь намын санхүүжилтийг зохицуулж буй өнөөгийн эрх зүйн актуудын зарим зүйл, заалтууд хэт ерөнхий, цоорхой ихтэй, үйлчлэлийн механизмууд нь хоёрдмол утга их агуулсан байгаа зэрэг нь тухайн хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, намуудын төлөвшилт, сонгуулийн үйл явцад зарим нэг бэрхшээлтэй асуудлуудыг үүсгэж байгааг судлаачид, улс төрчид ярьж, шүүмжилсээр байгаа билээ. Иймээс ойрын хугацаанд улс төрийн намын тухай хууль, сонгуулийн тухай хуулиудыг боловсронгуй болгох, ингэхдээ намуудын бүтэц, зохион байгуулалт, дотоод ардчилал, сонгуулийн үйл явцад оролцогч субъектүүдийн оролцоо, эрх үүрэг, сонгуулийн кампанит ажлын үе шат бүрийн нарийн чимхлүүр ажлууд, нам, сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал, хариуцлагын механизм зэргийг нэг бүрчлэн шинжилж хуулийн нарийн зохицуулалт хийх шаардлагатай. Монголын намуудын санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтанд тавих хяналт, хариуцлагын тогтолцоо их сул байна. Үүний сөрөг үр дагавар нь улс төр дэхь авилга, хээл хахууль болон аливаа тендер, хөтөлбөрийн сонгон шалгаруулалт зэрэг нь эрх мэдэлд ойр хүмүүстэй холбоотой бизнесийн бүлэглэлд давамгай эрх олгохоос эхлээд олон сөрөг үр дагаврууд нийгэмд бий болгосоор байгааг судалгааны байгууллагуудын судалгааны дүнгүүд харуулж байна.

Авилгатай Тэмцэх Газраас хийсэн “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авилгын талаарх төсөөлөл-2009” судалгааны дүнгээс үзэхэд “улс төрчдийн хүрээн дэх авилгын хэлбэр”-т дараах хэлбэрүүдийг судалгаанд оролцсон респондентууд онцлон нэрлэжээ (1-огт үгүй буюу авилга байхгүй, 5-маш их буюу авилга маш их дэлгэрсэн).

### Хүснэгт 1. Улс төрчдийн хүрээн дэх авилгын хэлбэр<sup>101</sup>

Хэлбэрүүд	Үнэлгээ
Сонгогчдын санал худалдан авах	4,7
Өөрийн өмчийн компани, аж ахуйн нэгжид давуу байдал олгох	4,7
Ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох	4,5
Намд хандив өгөх	4,5
Улс төрийн зорилгоор хууль бус хандив авах, өгөх	4,4
Бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах	4,4
Төсвийн мөнгийг зориулалтын бусаар өөрийн ашиг сонирхлоор зарцуулах	4,3
Төрийн өмчийг шамшигдуулах	4,2
Өөрийн эрх мэдлээ худалдах	4,0
Мөнгө угаах	4,0
Хувийн байгууллага, санд хандив өгөх	3,8
Хууль бусаар дампууруулах	3,6

Судалгааны дүнгээс харахад сонгуулийн болон улс төрийн намын санхүүжилттэй холбоотой авилга манай улсын хувьд нэн тулгамдсан асуудал болсон байгааг харж болохоор байна.

Эдүгээ Монголын улс төрийн намуудын санхүүжилтийг Улс төрийн намын тухай болон Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хууль, бусад холбогдох хууль, тогтоомжууд, намын дүрэм, санхүүжилтийн журмуудаар зохицуулж байгаа билээ. 2005 онд батлагдсан “Улс төрийн намын тухай” шинэ хууль таван бүлэг, хорин дөрвөн зүйлтэй. Үг хуулийн 4 дүгээр бүлэгт намын санхүүжилтийн заалтууд тусгагдсан. 16-р зүйлд намын хөрөнгө, орлого, 17 дугаар зүйлд намын орлогын зарцуулалт, 18 дугаар зүйлд гишүүний татвар, намд өгөх хандив, 19 дүгээр зүйлд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, 20 дугаар зүйлд намын санхүүгийн хяналт, 21 дүгээр зүйлд намын үйл ажиллагаанд тавих хяналт, 23 дугаар зүйлд намын үйл ажиллагааг зогсоох, намыг тараах, 24 дүгээр зүйлд хууль тогтоомж зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагын тухай тус тус хуульчилжээ.

<sup>101</sup> Авлигатай тэмцэх газар. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл-2009 судалгаа. [www.iaac.mn](http://www.iaac.mn)

## Улс төрийн намуудын санхүүжилтийн эх үүсвэрүүд

Улс төрийн намын тухай шинэ хуулийн 16-р зүйлийн 2 дахь хэсэгт намын санхүүжилтийн эх үүсвэрт хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө орох бөгөөд намын хөрөнгөд гишүүний татвар, гишүүн, талархан дэмжигч иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, намын бэлэгдэл бүхий бэлэг дурсгалын зүйлс, намын өмчлөлд байгаа эд юмс, намын хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны орлого, өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг худалдах буюу түрээслүүлж ашиглуулснаас олсон орлого, намын мөнгөн хөрөнгийг банкинд хадгалуулсны хувь зэрэг байхаар хуульчилсан. Манай намуудын хувьд гишүүдийн татвар, хандив, төрийн санхүүжилтээс санхүүжилтийн үндсэн эх үүсвэрээ бүрдүүлдэг. Харин хуульд заасан бусад эх үүсвэрүүдийн хувьд намын санхүүжилтийг бүрдүүлэхэд жинтэй нөлөө үзүүлж чадахгүй байна.

Мөн гишүүдийн татвар, хувь хүн ба хуулийн этгээдээс өгч буй хандив, төрөөс үзүүлдэг татаасууд ихэнх тохиолдолд нэр дэвшигчдэд бус улс төрийн намуудад цуглардаг. Намуудад очиж буй их хэмжээний мөнгийг тайлганах, нийтэд ил тод болгох тогтолцоог Улс төрийн намын тухай хуульд зохицуулж өгсөн боловч хуулийн хэрэгжилтийн байдал туйлын хангалтгүй байгаа юм. Ингээд намын санхүүжилтийн эх үүсвэрүүдийг тус бүрд нь авч үзье.

### 1. Гишүүний татвар.

Гишүүний татварын хэмжээ, татвар төлөх хугацаа, татвар хураах зэрэг асуудлыг намуудын дотоод дүрмээр зохицуулж байна. Улс төрийн намын тухай хуулийн 18.1-д гишүүн намын дүрмээр тогтоосон хэмжээгээр татвар төлөхөөр заасан байна. Тухайлбал, МАН (Монгол Ардын нам)-ын гишүүн сар бүр цалин, түүнтэй адилтгах орлогын 1 хувийг, ИЗН (Иргэний Зориг нам)-ын гишүүн сар бүр 300 төгрөгийн, ЭОН (Эх Орон нам)-ын гишүүн сар бүр 100 төгрөгийн, АН (Ардчилсан нам)-ын гишүүн сар бүр 100 төгрөгийн татварыг намдаа төлж байна. Үүнээс гадна намын сонгуулт гишүүн бүр намдаа өндөр хэмжээний хураамжийг төлдөг. МАН-ын Бага хурлын гишүүн улиралд 200000 төгрөг, АН-ын Үндэсний зөвлөлдөх хорооны гишүүн улиралд 250000 төгрөг, ИЗН-ын Улс төрийн зөвлөлийн гишүүн улиралд 668000 төгрөгийн татварыг тус тус төлдөг<sup>102</sup> байна.

### 2. Хандив.

Хуулийн этгээдээс улс төрийн нам, нэр дэвшигчдэд хандив өгөх асуудлыг намын хуульд “намд зориулж нэг удаа өгөх хандивын дээд хэмжээ хуулийн этгээдээс арван сая төгрөгөөс хэтрэхгүй бөгөөд нэг хандивлагч намын нэг байгууллагад жилд 2-оос дээш удаа хандив өгөхийг хориглоно. Намд хандив өгсний төлөө албан тушаал, хувийн эрх ашиг хөөцөлдөх, шахалт үзүүлэхийг хориглоно” гэж заасан. Энэхүү заалт нь манай улс төрчид, намууд хандивлагчаас хараат бус байх боломж, нөхцлийг хангахад бус харин хараат болох эрсдэлд оруулах эрх зүйн зохицуулалт болон хувирах магадлал өндөр байна.

<sup>102</sup> Монголын Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын боловсрол төв. Улс төрийн намын санхүүжилтийн мониторинг. УБ., 2007. 32 дахь тал

2008 оны УИХ-ын сонгуулийн өмнө намаас нэр дэвшиж сонгуульд өрсөлдөхийн тулд нэр дэвшигчид намдаа 20 сая төгрөгийн хураамж төлж байсан. Харин 2012 оны УИХ-ын сонгуульд намаасаа нэр дэвшихийн тулд намдаа өгөх хураамж нэлээд өсөх магадлал бий. Энэ нөхцөл байдал нь МУ-ын Үндсэн хуулинд заасан төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг зөрчиж байгаа юм.

Эндээс үзэхэд намуудын санхүүжилтийн гол эх үүсвэр нь хуулийн этгээд, хувь хүнээс өргөсөн хандиваас бүрдэж байгаа нь цаашид анхаарал татсан олон асуудлуудыг бий болгосоор байна. Мөнгө дагасан улс төр бий болох нөхцөл бүрдэж байна.

### 3. Төрийн санхүүжилт.

Намын тухай хуулийн 19 дүгээр зүйлд төрөөс авах санхүүгийн дэмжлэгийг дараах 2 төрлөөр байхаар хуульчилсан. Үүнд, Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналыг нийт хүчинтэй саналын тоотой харьцуулах зарчмаар нэг саналыг мянган төгрөгөөр тооцож, сонгуулийн дүн гарсны дараа гурван сарын дотор багтаан Улсын Их Хуралд суудал бүхий намд төр нэг удаа мөнгөн дэмжлэг үзүүлэх; УИХ-д суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор УИХ-ын гишүүний нэг суудлыг жилд 10 сая төгрөгөөр тооцож, УИХ-ын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгох бөгөөд санхүүжилтийн 50 хувийг УИХ-ын гишүүдийн сонгогдсон тойротг зарцуулдаг байна. 2000-2011 оны хооронд УИХ-д суудалтай намуудын санхүүгийн дэмжлэгт нийтдээ 6.9 тэрбум төгрөг олгожээ.

УИХ-ын гишүүний нэг суудлыг Улс төрийн намын 1990 оны хуулиар 1 сая төгрөгөөр тооцож төрөөс санхүүжилт олгож байснаа 2001 оноос 2.5 сая төгрөг болгон нэмсэн нь хууль зөрчсөн үйлдэл байсныг Үндэсний Аудитын газраас шалгаад хуульд өөрчлөлт оруулалгүйгээр санхүүжилтийн хэмжээг ингэж өсгөсөн нь хууль бус үйлдэл гэдгийг тогтоосон байдаг. Улс төрийн намууд өөрсөддөө төсвийн мөнгийг хууль бусаар хуваарилах, төсвөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг үндэслэлгүйгээр нэмэх, намд орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох хуулийн заалт байхгүй атал ИТХ-ын төлөөлөгчийн суудлын мөнгө гэх нэрээр 2000-2006 онд 1.8 тэрбум, 2009 онд 0,5 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна.

Монголын улс төрийн нам, эвслүүдийн төрөөс авсан санхүүжилтийг зарцуулсан ямар тооцоо, дүн байгаад хяналт тавих механизм байхгүй байгаа учраас УИХ-д суудалтай намууд төрөөс үзүүлэх санхүүжилтийг өөрсдийн үзэмжээр өсгөж байгаа бөгөөд үүнд иргэд сонгогчид төдийлөн таатай үнэлгээ өгөхгүй байна.


Намын тухай хуулийн 18 дугаар зүйлд, Нам хандивынхаа талаар нийтэд мэдээлж байна, мөн 20 дугаар зүйлд, Намын санхүүгийн үйл ажиллагаанд тухайн намын хяналтын байгууллага хяналт тавина. Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аudit хийлгэн баталгаажуулж нийтэд мэдээлнэ гэж хуульчилсан. Хуулийн дагуу Ардчилсан нам 2008 онд санхүүгийн үйл ажиллагаандаа аudit хийлгэсэн дүнгээ намын вэб хуудсандаа байрлуулсан

оловч олон нийтэд хүртээмжтэй хүргэх тал дээр асуудалтай байгаа юм. Иргэний Зориг нам аудит хийлгэсэн боловч дүнг нь нийтэд зарлаагүй нь хууль зөрчиж байгаагийн илрэл. Харин бусад намуудын хувьд санхүүгийн тайлангаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтийн хүртээл болгоогүй, хууль зөрчсөөр л байна.

2007 онд Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын боловсрол төвийн хамтарч хийсэн Улс төрийн намын санхүүжилтийн мониторингийн тайланд “намууд хандивлагчдын нэр болоод хандивын хэмжээ, хандивтай холбоотой бусад мэдээллийг маш их нууцалж байсан” гэж дурьдсан нь манай улс төрийн намууд хуулийн дээрх заалтуудыг биелүүлэх тал дээр хангартгүй ажиллаж байгааг харуулж байна. Мөн намын санхүүгийн үйл ажиллагаанд тухайн намын байгууллага хяналт тавина гэсэн нь намын санхүүжилтийн хяналтыг ёс төдий шинжтэй болгож, намуудыг дураар авирлах, хуулийн тодорхой бус байдлыг ашиглах өргөн боломжийг олгосоор байна. Улс төрийн намууд санхүүжилтийн журамдаа хандивын хэмжээ, зарцуулалтыг нээлттэй бус байлгах зохицуулалтууд нэлээдгүй хийсэн байна. Тухайлбал, АН-ын санхүүжилтийн журамд, Намын санхүүжилтийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, хуваарилалт, бүртгэлд тавих хяналт сонгуулт гишүүдэд ил тод байна<sup>103</sup> гэсэн нь намын жирийн гишүүд, дэмжигчид, олон нийтэд хаалттай байх нөхцөл болж байгаа юм. МАН-ын санхүүжилтийн журамд зааснаар санхүүжилтийн зарчим нь, Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд олон нийт, гишүүдэд нээлттэй, ил тод байхаар заасан байдаг боловч намын гишүүд дэмжигчдэд санхүүжилтийн асуудал хаалттай, дээрх заалт хэрэгжихгүй явсаар өдий хүрчээ.

Судлаач Э.Гэрэлт-Одын улс төрийн намуудын гишүүдийг хамруулсан судалгаа<sup>104</sup>-ны дүнгээс харвал, “Танай нам гишүүд, дэмжигчиддээ 2006 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангаа танилцуулсан уу” гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 25,3 хувь нь “тийм”, үлдсэн 74,7 хувь нь “үгүй” болон “мэдэхгүй” гэсэн хариулт өгчээ.

Бүдүүвч 1. Санхүүгийн үйл ажиллагааны нээлттэй байдал



<sup>103</sup> Ардчилсан намын дүрэм, журмын эмхтгэл. УБ., 2009, 58 дахь тал

<sup>104</sup> Э.Гэрэлт-Од. Монголын улс төрийн намуудын дотоод ардчилал. Ардчилал ба улс төрийн намууд. Онол практикийн бага хурал. УБ., 2009. 33 дахь тал

Дээрх судалгаанаас харахад улс төрийн намууд гишүүд, дэмжигчиддээ намын үйл ажиллагаандaa зарцуулсан санхүүгийн тайлангаа танилцуулж, тайлагнах асуудал хангалтгүй байгааг илтгэж байна.

### Хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизм

Намын хуулийн 24 дүгээр зүйлд хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тухай заасан. Намын тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол Эрүүгийн хуулиар, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол захиргааны хариуцлагыг шүүгч ногдуулах ба дараах зөрчилд албан тушаалтанг 40000-60000 төгрөг, намыг 200000-250000 төгрөгөөр торгохоор тогтоожээ. Үүнд:

1. хуулиар хориглосон хэлбэрээр ашиг олох;
2. намын орлогоос ногдол ашиг хуваарилах, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлбөрийг төлөх;
3. данснаас гадуур болон хуулиар тогтоосон хэмжээнээс илүү хандив авах;
4. хуулиар хориглосон этгээдээс хандив авах;
5. намын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэхээс зайлсхийх, аудит хийлгэсэн боловч нийтэд мэдээлэгүй бол дээрх хариуцлагыг хүлээлгэхээр байна.

Эндээс үзэхэд хуулийн заалтууд зөрчигдөхөд хүлээлгэх хариуцлагын хэмжээ нь тодорхой бус, хүлээлгэж буй хариуцлага нь сул, торгуулийн хэмжээ нь хэт бага байна. Иймээс улс төрийн намын тухай хуулийг зөрчсөн албан тушаалтан, байгууллагад хүлээлгэх хариуцлагын механизм нь хуулийг нэг мөр сахин биелүүлэх, хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэрэгсэл болж чадахгүй байна.

### ДҮГНЭЛТ

Энэ бүгдээс үзэхэд улс төрийн намын санхүүжилтийн эрх зүйн зохицуулалт Монголд хангалтгүй байгаа нь харагдаж байна. Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад улс төрийн санхүүжилтийн хэлбэр, механизмуудад хяналт тавих, хариуцлага тооцох, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар тодорхой “амьд” зохицуулалтууд хийгдээгүй учраас намуудын хариуцлага бүхэлдээ суларч, санхүүжилтээ хууль зөрчиж босгох, төрөөс олгосон санхүүжилтийг зориулалтын бус үйл ажиллагаанд зарцуулах, орлого, зарлагын мэдүүлгээ тайлагнахгүй байх зэрэг олон зөрчил, дутагдлууд бодитой байсаар байна.

Иймд нам, улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хариуцлагын механизмыг дээшлүүлэх нь улс төрийг “цэвэр, тунгалаг” болгох тулгамдсан асуудлуудын нэг мөн. Үүнийг Намын тухай хууль, УИХ-ын сонгуулийн тухай хууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Орон нутгийн сонгуулийн тухай хуулин дахь санхүүжилтийн механизм, зохицуулалтуудыг уялдуулж боловсронгуй болгох, мөн нам болон улс төрийн санхүүжилтийн хуулийг тус тусад нь боловсруулж гаргах замаар шийдвэрлэх боломжтой юм.

Нам, улс төрийн санхүүжилтийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага ч тийм байна. Монголын улс төрийн намууд хуулийг биелүүлэх талын санал зөвлөмжийг улс төрийн намууд, төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийтийн байгууллагын оролцоотойгоор гаргах, зөрчсөн тохиолдолд чанга хатуу хариуцлага хүлээнгэдэг болох, хууль зөрчсөн эсэхэд нь мониторинг хийдэг судалгааны багуудыг ажиллуулах гэх мэт олон аргуудыг энд хэрэглэх шаардлагатай байна.

**Түлхүүр уг:** Улс төрийн санхүүжилт, намын санхүүжилт, санхүүжилтийн эрх зүйн орчин, татвар, хандив, улс төрийн авилга

**Товч хураангуй:** Орчин үеийн намын хөгжил, төлөвшилтэд нам, намаар дамжсан улс төрийн санхүүжилтийн ил тод байдал, эрх зүйн нарийн зохицуулалт чухал ач холбогдолтой болсныг ардчилал хөгжсөн орнуудын туршлага бэлхэнээ харуулж байна. Хөгжингүй орнуудад улс төрийн намууд өөрсдийн хичээл зүтгэлээр хуулийн хүрээнд мөнгө босгож сонгуульд нэр дэвшигчдээ санхүүжүүлдэг.

## ABSTRACT

The issues of money and its effect on politics is increasingly gaining attention in the Mongolia in the same way as in other parts of the world. In fact, the experience Western democracies has shown the continuing difficulty of eliminating political corruption. However, in Mongolia there is an additional problem. Will the public there accept changes in their relations with elected representatives, for instance, ceasing to expect "gifts" for major family events, as part of the price of changes? This is especially a problem if the total amount available for subsidies to political parties is based upon a multiple of the total population.

multiple of the total population. Every taxpayer may feel that he or she is entitled to some return for his or her contribution, especially if politicians are suspected of having raked off disproportionate benefits for themselves. In that case the extreme pressures on political funding, often deteriorating into corruption, will continue. Without significant changes in public expectations, the problem of political corruption in Mongolia cannot be fundamentally addressed.

НОМ ЗҮЙ

Хууль, дурэм, албан баримт бичиг

1. Ардчилсан Намын дүрэм, журмын эмхэтгэл. УБ.,2009
  2. Монгол Ардын Намын хичээн эрмэлзэх зүйл, дүрэм. УБ.,2010
  3. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. №01. УБ.,1992.
  4. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль. Төрийн мэдээлэл. №5. (434). УБ.,2006
  5. Монгол Улсын Улс төрийн намын тухай хууль. Төрийн мэдээлэл. №7. (338). УБ.,2005.

Сүлднэгүй

- Судалгааны бичүүлэл

  6. Авлигатай тэмцэх газар. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл-2009 судалгаа. <http://www.iaac.mn/>
  7. Гэрэлт-Од. Э. Монголын улс төрийн намуудын дотоод ардчилал. Ардчилал ба улс төрийн намууд. Онол практикийн бага хурал. УБ.,2009
  8. Монголын Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын боловсрол төв. Улс төрийн намын санхүүжилтийн мониторинг. УБ.,2007
  9. Мөнхбат. С. Улс төрийн намын санхүүжилт, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудалд. УТШУ-ны Альтернатив сэтгүүл. УБ.,2003
  10. Austin, R. and Tjernstrom. The International IDEA Handbook series: Funding of Political Parties and Election Campaigns. 2003. [www.idea.int/publications/funding\\_parties/upload/full.pdf](http://www.idea.int/publications/funding_parties/upload/full.pdf)
  - 11 Sandy Maisel. L. Parties and Elections in America. The electoral process. USA.,1993